



**ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН  
ШАРГА СУМЫН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

20 17 оны 04 сарын 03 өдөр

Дугаар A/09

Баянгол

┌ Зөвшөөрөл олгох тухай ┐

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Усны тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.5 дахь заалт, Аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын 2017 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн Ус ашиглуулах тухай 100 дугаар дүгнэлтийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Тус сумд орших 017824XV дугаартай тусгай зөвшөөрөл бүхий Бор толгой нэртэй талбайг эзэмшигч "Арголд" ХХК-д 2017 онд ажиллагсдын унд ахуйн хэрэгцээнд 450 м<sup>3</sup>, эрэл хайгуулын өрөмдлөгт ашиглах 9696 м<sup>3</sup> ус ашиглахыг зөвшөөрсүгэй.

2. Усны тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.11, 29 дүгээр зүйлийн 29.1 дэх заалтуудыг тус тус үндэслэн "Арголд" ХХК-тай ус ашиглах гэрээ байгуулж, эрхийн бичиг олгохыг Байгаль орчны хяналтын улсын байцаагч /Б.Оюунтүлхүүр/, Байгаль хамгаалагч /Б.Шинэхүү/ нарт зөвшөөрсүгэй.

3. Ус ашиглалтыг зөвшөөрсөн хэмжээнээс хэтрүүлэн ашиглах, гэрээнд заасан төлбөрийг хугацаанд нь төлөх, ашиглалтын зориулалтыг өөрчлөхгүй байх, ус ашиглалтын тайлан, мэдээг жил бүрийн 12 дугаар сарын 20-ны дотор тайлагнаж байхыг "Арголд" ХХК-д даалгасугай.

4. Энэхүү захирамж болон ус ашиглах гэрээний хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Байгаль орчны хяналтын улсын байцаагч /Б.Оюунтүлхүүр/, Байгаль хамгаалагч /Б.Шинэхүү/ нарт даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



М.ТУНГАЛАГТАМИР

C/barimt/zahiramj/2017

00700036



ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН  
ШАРГА СУМЫН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

20 17 оны 04 сарын 17 өдөр

Дугаар А/10

Баянгол

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6-ийн “а”, 29.2 дахь заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Бүрэн дунд сургуулийн 12 дугаар ангийн сурагчдын дунд “Алтай ЭЕШ-2017” шалгалтыг зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ахлагч: Р.Оюунчимэг /ЗДТГ-ын дарга/

Хянагч багш: П.Гантулга /Бага ангийн багш/

А.Алтанцэцэг /Бага ангийн багш/

П.Ариунжаргал /Бага ангийн багш/

Н.Ариунбилэг /Бага ангийн багш/

Сэдэв хариуцагч: Б.Хорлоожав /Нийгмийн даатгалын байцаагч/

Зохион байгуулагч: Н.Гэрэлмаа /Санхүүгийн албаны дарга/

Л.Оюунбилэг /Нягтлан бодогч/

2. Шалгалтыг чанартай, хариуцлагатай зохион байгуулж шалгалтын материалыг битүүмжлэн, заасан баримт бичгийн хамт хугацаанд нь нийгмийн бодлогын хэлтэст хүргүүлэхийг ажлын хэсгийн бүрэлдэхүүнд даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



М.ТУНГАЛАГТАМИР

C/barimt/zahiramj/2017

00700038



ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН  
ШАРГА СУМЫН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2017 оны 04 сарын 17 өдөр

Дугаар А/М

Баянгол

2017 оны 1 дүгээр ээлжийн цэрэг  
татлагын ажлыг зохион байгуулах  
тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Иргэний цэргийн үүргийн болон цэргийн албан хаагчдын эрхзүйн байдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2 дахь заалт, аймгийн Засаг даргын 2017 оны А/120 дугаар захирамжийг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. 2017 оны 1 дүгээр ээлжийн цэрэг татлагыг зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Р.Оюунчимэг /Засаг даргын тамгын газрын дарга/

Гишүүд: С.Цогзолмаа /Эрүүл мэндийн төвийн дарга/

Т.Гэндэнсүрэн /Хэсгийн төлөөлөгч/

Г.Ган-Очир /Баянгол багийн Засаг дарга/

Ж.Эрдэнэпүрэв /Хамтын хүч багийн Засаг дарга/

Ц.Даваадорж /Сондуулт багийн Засаг дарга/

Б.Гантулга /Улаантуг багийн Засаг дарга/

2. Цэрэгт татагдсан иргэдийг эрүүл мэндийн үзлэгт хамруулж, татлагын товчооны үзлэгт биеэр оролцохыг С.Цогзолмаад даалгасугай.

3. Цэрэг татлагыг зохион байгуулсан, цэргийн насны иргэдийг эрүүлжүүлсэн тухай илтгэх хуудсыг танилцуулахыг засаг даргын тамгын газрын дарга /Р.Оюунчимэг/, Эрүүл мэндийн төвийн дарга /С.Цогзолмаа/ нарт даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



М.ТУНГАЛАГТАМИР

C/barimt/zahiramj/2017

00700040



**ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН  
ШАРГА СУМЫН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2017 оны 04 сарын 18 өдөр

Дугаар А/а

Баянгол

Г Хөрөнгө зарцуулах тухай Г

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Сангийн сайдын 2012 оны 239 дүгээр тушаалын "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2.1, 2.3 дахь заалт, сумын Засаг даргын зөвлөлийн 2017 оны 04 дүгээр сарын 17-ны өдрийн 03 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сумын гэгээрлийн өргөөнд бурхны ном хурах үйл ажиллагааны зардлын 100000 төгрөг, 2017 оны 03 дугаар сарын 22-23-ны шилжих шөнийн хүчтэй шороон болон цасан шуурганд төөрсөн иргэнийг эрж хайх ажиллагааны шатахууны зардалд 385450 төгрөгийг засаг даргын нөөц хөрөнгөөс гаргаж зарцуулахыг санхүүгийн албаны дарга /Н.Гэрэлмаа/, нягтлан бодогч /Л.Оюунбилэг/ нарт зөвшөөрсүгэй.

3. Санхүүгийн анхан шатны баримтыг захирамжид хавсаргахыг нярав /Б.Уранцэцэг/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



М.ТУНГАЛАГТАМИР

C/barimt/zahiramj/2017

00700055





ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН  
ШАРГА СУМЫН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

20 17 оны 04 сарын 18 өдөр

Дугаар А/13

Баянгол

Г Зөвлөл шинэчлэн байгуулах тухай Г

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь заалт үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сумын Засаг даргын зөвлөлийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Засаг дарга

Засаг даргын тамгын газрын дарга

Сургуулийн захирал

Эрүүл мэндийн төвийн эрхлэгч

Цэцэрлэгийн эрхлэгч

Соёлын төвийн эрхлэгч

Мал эмнэлэг, үржлийн тасгийн дарга

Санхүүгийн албаны дарга

Үйлдвэрчний эвлэлийн дарга

Баянгол багийн Засаг дарга

Ахмадын холбооны дарга

2. Зөвлөлийн хурлын үйл ажиллагаанд санаачлагатай оролцож, засаг даргаас гаргах шийдвэрт тусгах асуудалд хуулийн хүрээнд бодит байдлаар хандаж оролцохыг зөвлөлийн гишүүнд зөвлөсүгэй.

3. Зөвлөлийн хурлын тэмдэглэлийг албажуулж, шийдвэрийн хэрэгжилтийг хангаж ажиллахыг дотоод ажил, шийдвэрийн биелэлт хариуцсан мэргэжилтэнд даалгасугай.

4. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан 2015 оны А/14 дүгээр захирамжийг хүчингүй болгосугай.

ЗАСАГ ДАРГА



М.ТУНГАЛАГТАМИР

C/barimt/zahiramj/2017

00700045



ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН  
ШАРГА СУМЫН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

20 17 оны 04 сарын 24 өдөр

Дугаар А/14

Баянгол

Тээврийн хэрэгслийн техникийн  
хяналтын үзлэг зохион байгуулах  
тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь заалт, Авто тээврийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.1 дэх заалт, 17 дугаар зүйлийн 17.2 дахь заалт, 21 дүгээр зүйл, Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.3 дахь заалт, аймгийн Засаг даргын 2017 оны А/36 дугаар захирамжийг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Тээврийн хэрэгслийн хяналтын үзлэгийг зохион байгуулах ажлын хэсгийг хавсралтаар баталсугай.
2. Авто тээврийн улсын үзлэгийн хуваарийг иргэд, аж ахуйн нэгжид сурталчлах, үзлэгт машин техникийг хугацаанд нь бүрэн хамруулах, бэлтгэл ажлыг хангах сумын нэгдсэн төлөвлөгөө гарган, хэрэгжилтийг ханган ажиллахыг ажлын хэсгийн бүрэлдэхүүнд даалгасугай.
3. Тээврийн хэрэгслийн татвар хураалтыг тогтоосон хувь хэмжээний дагуу хугацаанд нь хурааж төвлөрүүлж дуусгахыг татварын байцаагч /Н.Гантөмөр/-д үүрэг болгосугай.
4. Албан журмын даатгалын тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллахыг даатгалын төлөөлөгч нарт үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



М.ТУНГАЛАГТАМИР

C/barimt/zahiramj/2017

00700047

Сумын Засаг даргын 2017 оны 04  
дугаар сарын 24-ны өдрийн 4/14  
дугаар захирамжийн хавсралт

АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын хэсгийн ахлагч: М.Тунгалагтамир /Засаг дарга/

Нарийн бичгийн дарга: Х.Төртулга /Засаг даргын орлогч/

Гишүүд: Н.Гантөмөр /Татварын байцаагч/

Т.Гэндэнсүрэн /Хэсгийн төлөөлөгч/

Ж.Сайнбилэг /Цагдаа/

Г.Очирсүрэн /Олон нийтийн байцаагч/

Г.Ган-Очир /1 дүгээр багийн Засаг дарга/

Ж.Эрдэнэпүрэв /2 дугаар багийн Засаг дарга/

Ц.Даваадорж /3 дугаар багийн Засаг дарга/

Б.Гантулга /4 дүгээр багийн Засаг дарга/



ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН  
ШАРГА СУМЫН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

20 17 оны 04 сарын 24 өдөр

Дугаар A/15

Баянгол

Зээл олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь заалт, Засгийн газрын 2016 оны 153 дугаар тогтоолын "Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах, хяналт тавих журам"-ын 4.5 дахь заалт, сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2016 оны 08 дугаар тогтоол, Төсөл сонгон шалгаруулах зөвлөлийн 2017 оны 04 дүгээр сарын 17-ны өдрийн 01 дүгээр шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Төсөл сонгон шалгаруулах зөвлөлийн хурлын шийдвэрийн дагуу хавсралтад дурдсан 3 иргэнд журмын дагуу зээл олгохыг санхүүгийн албаны дарга /Н.Гэрэлмаа/, ня-бо /Л.Оюунбилэг/ нарт зөвшөөрсүгэй.
2. Зээл авсан иргэдтэй гэрээ байгуулж, холбогдох бичиг баримтыг бүрдүүлэхийг /Х.Төртулга/, төслийн явц, үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллахыг /Н.Ганзориг/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА  М.ТУНГАЛАГТАМИР





Сумын Засаг даргын 20<sup>17</sup> оны <sup>04</sup>  
дугаар сарын <sup>24</sup> -ны өдрийн <sup>4/15</sup>  
дугаар захирамжийн хавсралт

№	Төслийн нэр	Төсөл санаачлагч	Санхүүжүүлэхээр шийдвэрлэсэн зээлийн хэмжээ
1.	"Арвайн гурил" төсөл	Д.Ганболд	3 сая
2.	"Түмэн сүрэг" төсөл	Д.Батмөнх	3 сая
3.	"Борц" төсөл	Д.Мөнх-Эрдэнэ	3 сая
4.	Нийт дүн		9 сая